



КРЕДИТ
ББСБ

Хагас жилийн тайлан




Алсын хараа

Ард Кредит нь санхүүгийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн зах зээлд манлайлж ажиллана.

Эрхэм зорилго

Бид Монгол Улсад санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, санхүүгийн боловсролыг дэлгэрүүлэх зорилго бүхий нийгмийн хариуцлагын тэргүүлэгч байгууллага болно.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт

Ард Кредит ХК нь нээлттэй хувьцаат болсны дараа нийт 1,432 хувьцаа эзэмшигчтэй болсон бөгөөд үүнээс топ 11 хувьцаа эзэмшигч 1.27% болон түүнээс дээш хувийг эзэмшиж байв. 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн тоо 1,530 болж өөрчлөгдсөн ба топ 11 хувьцаа эзэмшигчид өөрчлөлт ороогүй байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөл



Чулууны Ганхуяг

ТУЗ-ийн дарга
Ард Санхүүгийн Нэгдэл ХХК
Гүйцэтгэх захирал



Сэдбазарын Гэрэлтуяа

ТУЗ-ийн ердийн гишүүн
Мон-Интернэйшнл ХХК
Гүйцэтгэх захирал



Ванданцэрэнгийн Баяржаргал

ТУЗ-ийн ердийн гишүүн
Интергрупп Интернэйшнл ХХК
Гүйцэтгэх захирал



Майнбаярын Тулгат

ТУЗ-ийн ердийн гишүүн
Хишиг Арвин Индустриал ХХК
Дэд захирал



Чулууны Ганзориг

ТУЗ-ийн ердийн гишүүн
Ард Кредит ББСБ ХК
Гүйцэтгэх захирал



Ванчигийн Ганзориг

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Бат Сольюшн Партнерс ХХК
ТУЗ-ийн дарга



Барамсайн Ганбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Техник технологийн дээд сургууль
Гүйцэтгэх захирал



Базын Чулуунбаатар

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Моннис Интернэйшнл ХХК
Ерөнхий захирал



Ишдоржийн Баттуяа

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Жамоторабэрү ХХК
Гүйцэтгэх захирал

Компанийн тухай



Стратеги

Манай компани нь дэлхийн томоохон банк, санхүүгийн байгууллагуудын чиг хандлага болоод байгаа финтек санхүүгийн байгууллага болох зорилт тавин санхүүгийн уламжлалт үйл ажиллагааны арга барилаас финтек бизнесийн загвар руу эргэлт буцалтгүй шилжээд байна. Энэ зорилгын хүрээнд бид орчин үеийн санхүүгийн дэвшилтэт технологи, хамтран ажиллагч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан Монгол Улсын иргэн бүрт санхүүгийн үйлчилгээг салбар нэгж, тооцооны төвгүйгээр цахим хэлбэрээр хүргэдэг болох төлөвлөгөөтэй ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд бид өнгөрсөн нэгдүгээр


сард Ард Апп буюу санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх ухаалаг гар утасны аппликейшнийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Ард Апп нь банкны программ хангамж, төлбөр тооцооны систем хийх олон жилийн туршлагатай Грэйпсиги Монголиа ХХК болон Мост ПСП ХХК-тай хамтран бүтээж, харилцагчиддаа үйлчилгээгээ хүргэж байгаа бөгөөд Монгол Улсын үндэсний хэмжээний цахим төлбөр тооцооны систем болох Мост Мони систем болон Мост Скор системийн дэд бүтэц дээр суурилан ажиллаж байна.



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Манай компани Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны зээлийн үйл ажиллагаа, гадаад валютын арилжаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, хаалттай өрийн бичиг, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд зээлийн үйл ажиллагааг голлон эрхэлж байна.

2019 оны II улиралд нийт 33,170 иргэн, аж ахуй нэгжид 14,6 тэрбум төгрөгийн цэвэр зээл олгож, зээлийн багц 13,0 тэрбум төгрөгт, зээлдэгчийн тоо 18,752 тус тус хүрсэн байна. Идэвхтэй зээлийн тоо 2,150 хувиар өсч, зээлийн дундаж хэмжээ 694,2 мянган төгрөг болж буурсан байна.



All-in-One Platform

Ард Апп

₮13.7 тэрбум Зээл олгов

33,170 Зээл олголт

139,600 Харилцагч

2.9% Чанаргүй зээл

47,314 Эргэн төлөлт

56% 

44% 

65.6%


19.6% **14.8%**

18-30 нас

30-45 нас

45+ нас

2019 оны II улирлын байдлаар



ХАРИЛЦАГЧ ӨӨРИЙГӨӨ БҮРТГЭХ

Та салбар дээр ирэлгүйгээр хиймэл оюун дээр тулгуурласан технологийн тусламжтайгаар гар утсаараа манай харилцагч болох боломжтой

ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Та хаанаас ч, хэзээ ч гар утсаараа дамжуулан 2 сая хүртэлх төгрөгийн БАРЬЦААГҮЙ зээлийг 3 минутад авах боломжтой боллоо

ХУВЬЦАА

Та онлайнгаар үнэт цаасны дансаа удирдаж, арилжаанд оролцох боломжтой

БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИ

Монголын анхны цахим арилжааны бирж болох Trade.mn дээрх крипто валютын дансаа удирдах боломжтой

АРД ШОП

Бүх төрлийн бараа бүтээгдэхүүнийг хамгийн хялбараар захиалан хүргүүлж авах боломжтой онлайн дэлгүүр

QPAY ҮЙЛЧИЛГЭЭ

QR код ашиглан төлбөр төлөх, нэхэмжлэл үүсгэх болон өөрийн дансандаа ОРЛОГО хүлээн авах QR код үүсгэх боломжтой

ЗЭЭЛИЙН ТООЦООЛОЛ

Хиймэл оюун ухаан болон тоон өгөгдөл дээр үндэслэсэн зээлийн тооцоолол

ХУРИМТЛАЛ

Өндөр өгөөж бүхий хуримтлалын дансаа банкинд очилгүйгээр нээх боломжтой

ТӨЛБӨР ТООЦОО

Хэрэглээний төлбөрөө төлөх, тогтмол шилжүүлэг болон автомат шилжүүлэг

БЭЛЭН МӨНГӨ

Банкны картгүйгээр АТМ-с бэлэн мөнгө авах боломжтой

ЛОЯЛТИ

Та манай бүх компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээ авсан тохиолдолд танд олгогдох урамшуулал оноо юм

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Манай харилцагчийн үйлчилгээний төв болон салбар дээрх баг танд хэзээд туслахад бэлэн



Үйл ажиллагаа

- 2018 онд Ард Кредит нь нээлттэй компани болох зөвшөөрлөө Монголын Хөрөнгийн Биржээс гардан авч, 2019 оны I улиралд хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн захиалга 299 хувь даван биелж, 1,500 гаруй шинэ хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болж чадлаа.
- Хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилсний дараах анхны хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр амжилттай зохион байгуулав. Уг хурлаар 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг 3 жилийн хугацаатайгаар сонгов.
- Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Апп-н II хувилбарыг Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2019 чуулга уулзалтын үеэр олон нийтэд танилцуулав.
- Бид Монгол Шуудан ХК-ийн Дархан, Эрдэнэт дахь салбаруудаар Ард Апп-р авах зээлийн гэрээг байгуулж эхлэв.
- Жил бүр зохион байгуулагддаг Бичил Санхүүгийн Төвийн 2019 оны хуралд Алтан спонсороор баг, хамт олноороо амжилттай оролцов.
- Япон улсын Крауд Кредит сантай хамтран ажиллах 5 сая долларын санхүүжилтийн гэрээний дагуу 3-н удаагийн санхүүжилт компанийн дансанд орж ирлээ.



Ард Кредит IPO

ARD КРЕДИТ
ББСБ

(MSE:ADB)

₮70-85

Нэгж хувьцааны үнэ

70 сая (25%)

Санал болгосон хувьцаа

Анхдагч зах зээлийн захиалга **2019.2.18 - 2019.3.1**

Хоёрдогч зах зээл дахь арилжаа **2019.3.12**

Татан төвлөрүүлэх дүн

5.3

тэр бум төгрөг

Нийт захиалгын дүн

7.3

тэр бум төгрөг

Анхдагч арилжааны
захиалга

299%

Давж биелэв

Хувьцаа эзэмшигчид

4.9%

В.Баяржаргал

9.5%

С.Гэрэлтуяа

25%

Олон Нийт

60.5%

Ард Санхүүгийн
Нэгдэл

30.1%

0-30 нас

62.6%

31-60 нас

7.3%

60+ нас




Хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН хурал

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлаараа анхны хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шийдвэр гаргаж хурал 2019 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр Зайсан Хилл Комплекст амжилттай зохион байгуулагдаж өнгөрлөө. Хуралд нийт 317 хувьцаа эзэмшигч оролцож, компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталж, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох шийдвэрүүдийг гаргасан билээ. Уг шийдвэрийн дагуу өмнөх ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрх дуусгавар болсон.

Огноо: **2019.4.27**

Ирц: **81%**

Шийдвэрлэсэн асуудлууд: **Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах**
Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ШИЙДВЭРҮҮД

Компанийн ТУЗ нь 2019 оны эхний хагас жилд ээлжит болон ээлжит бус хурлыг нийтдээ 2 удаа, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг тус бүр 1 удаа хуралдуулж, дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

ТУЗ-ийн хурлын шийдвэрүүд:

Огноо: **2019.3.18**

Ирц: **100%**

ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДЛУУД: **Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах**

Огноо: **2019.4.11**

Ирц: **100%**

ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДЛУУД: **Өмнөх хурлын шийдвэр, биелэлт
ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлаас гарсан зөвлөмжийг танилцуулах
2019 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан
Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах**



ТУЗ-ийн дэргэдэх хороодоос гарсан зөвлөмжүүд:

Огноо: **2019.4.8**

Дотоод аудитын хороо **2018 оны аудитлагдсан тайланд дүгнэлт гаргах**
Аудитын дүгнэлтийн талаар

Огноо: **2019.4.8**

Зээл, эрсдэлийн хороо **2018 оны IV улирлын зээлийн тайлан**
2019 оны I улирлын зээлийн тайлан

Огноо: **2019.4.8**

Засаглалын хороо **2018 оны Гүйцэтгэх захирлын KPI үнэлгээ**
2019 оны Гүйцэтгэх захирлын KPI батлах
Гүйцэтгэх захирлын залгамж халаа төлөвлөх
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох
ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн жагсаалт эцэслэх
ТУЗ-ийн гишүүдийн цалин батлах
Сэнтрал Тауэр салбарын захирал томилох



Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

Тайлант хугацаанд Маркетинг хариуцсан захирлаар Д.Сувдмаа, Сэнтрал Тауэр салбарын захирлаар Д.Мөнх-Од тус тус томилогдсон байна.

Эрх бүхий албан тушаалтнууд



Ч.Ганзориг

Гүйцэтгэх захирал



Д.Отгонжаргал

Зээл эрхэлсэн захирал



Д.Сувдмаа

Маркетинг хариуцсан
захирал



Д.Мөнх-Од

Салбарын захирал




Д.Дархижав

Ерөнхий нягтлан
бодогч



М.Мөнхсүрэн

ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга



Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл

Баталсан эрх бүхий этгээд	Хэлцлийн тал	Хэлцлийн агуулга	ТУЗ-аар хэлэлцүүлэх болсон үндэслэл
ТУЗ	Тэнгэр Системс ХХК /Зэргэлдээ компани /	Ажил гүйцэтгэх гэрээ	Сонирхлын зөрчилтэй хэлцэл
ТУЗ	Ард Капитал ҮЦК ХХК	Харилцагч төвлөрсөн хадгаламжийн гэрээ	Гүйцэтгэх захирлын саналаар

Ногдол ашгийн талаар мэдээлэл

Ард Кредит ХК нь Үнэт цаасны танилцуулгадаа 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байх талаар тусган 2019 оны төсөв, төлөвлөгөөг баталсан тул ТУЗ-аас ногдол ашиг хуваарилахгүй байх шийдвэр гаргасан. ТУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн ээлжит хурлаар Хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилсөнтэй холбогдуулан “Ногдол ашгийн бодлого”-ыг батлаад байна.

ЗЭЭЛ, ЭРСДЭЛИЙН ХОРОО
ГАНБАТ ДАРГА
ГЭРЭЛТУЯА ГИШҮҮН
ГАНЗОРИГ ГИШҮҮН

ЗАСАГЛАЛЫН ХОРОО
ЭРЭЛТУЯА ДАРГА
БАЯРЖАРГАЛ ГИШҮҮН
УЛГАТ ГИШҮҮН

ДОТООД АУДИТЫН ХОРОО
НЗОРИГ ДАРГА
НБАТ ГИШҮҮН
ЯРЖАРГАЛ ГИШҮҮН

Санхүү байдлын хураангуй тайлан



Ард Кредит II улирлын тайлан

(Сая төгрөг)	Q2 2018	Q4 2018	Q2 2019	YTD	YoY
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,431.2	1,123.7	3,003.8	167%	110%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	392.3	671.3	609.2	-9%	55%
Цэвэр зээл	6,750.3	7,477.7	12,707.3	70%	88%
Бусад хөрөнгө	595.2	982.8	1598.2	63%	169%
Үндсэн хөрөнгө	325.5	216.3	741.2	243%	128%
НИЙТ ХӨРӨНГӨ	9,494.5	10,471.8	18,659.7	78%	97%
Эх үүсвэрийн өглөг	5,924.1	6,186.50	8,071.70	30%	36%
Бусад өглөг	472.9	527.9	1014.2	92%	114%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,397	6,714.4	9,085.9	35%	42%
Энгийн хувьцаа	2,100	2,100	2,800	33%	33%
Нэмж төлөгдсөн капитал	0	0	4,048.50		
Хуримтлагдсан ашиг	1,315.30	1,315.30	1,657.4	26%	26%
Тайлант хугацааны ашиг	-317.9	342.1	1,067.9	212%	436%
ЭЗДИЙН ХӨРӨНГӨ	3,097.4	3,757.4	9,573.8	155%	209%
(Сая төгрөг)	2018 II	2018 IV	2019 II	YTD	YoY
Хүүгийн орлого	780.4	1,777.9	1,330.6	-25%	71%
Шимтгэлийн орлого	46.9	84.6	676.4	699%	1342%
Бусад орлого	20.8	434.5	671.1	54%	2126%
НИЙТ ОРЛОГО	8,48.1	2,297	2,678.1	17%	216%
Хүүгийн зардал	457.7	915.1	517.1	-43%	13%
Эрдслийн сангийн зардал	224.3	1.7	211.4	12335%	-6%
Үйл ажиллааны зардал	484.1	987.1	757.4	-23%	56%
НИЙТ ЗАРДАЛ	1,166.1	1,905.8	1,48449	-22%	27%
Татварын өмнөх ашиг	-317.9	391.2	1,193.70	205%	-475%
Орлогын татвар		49.2	125.7	156%	
Цэвэр ашиг	-317.9	342	1,067.90	212%	-436%

